



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР**



# **Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ**



**2023 оны 7 дугаар сарын байдлаар**

**Мөрөн сум**

## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар 1292 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдол буюу 0,3%-иар буурсан байна. Төрөлт Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Их-уул, Рашаант, Рэнчинлхүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Улаан-Уул, Ханх, Цагаан-Уул, Цагааннуур сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 74,2% байна.




### ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар нийт 1298 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 2,4 хувь /31/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 97,0 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2023 оны эхний 7 сард нийт 35580 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 28.9 хувь нь А амин дэм, 57.1 хувь нь Д амин дэм, 3.2 хувь нь олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн байна.

## НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 6 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 9.2 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 33.3 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 3.1 байна. Нийт 7 тохиолдол буюу 58.3 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 6 нь эрэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:



## 1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2023 оны эхний 7 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6 тохиолдлоор өссөн байна. 1000 амьд төрөлтөнд 6,9 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл хавдар 1, дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 2, төрөлхийн гаж хөгжил 1, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 4 тохиолдол бүртгэгдсэн байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бодит тоогоор




5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2023 оны эхний 7 сарын байдлаар



## НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ


2023 оны эхний 7 сарын байдлаар 424 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 32 тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 19,3 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 36,6 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 58 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 25 тохиолдолоор буурсан, нийт нас баралтын 13,7 хувийг эзэлж, 10000 хүн амд 4,2 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 123 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 11 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 29,0 хувийг эзэлж, 10000 хүн амд 8,9 ногдож байна.

Нас баралтын мэдээлэл, 2023 оны эхний 7 сарын байдлаар



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/


1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 11.9
2. Хавдар-8.9
3. Гадны шалтгаант өвчлөл- 4.2
4. Амьсгалын тогтолцооны өвчин-1.9
5. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-1.7




Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 765, эсийн шинжилгээ 3647 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 56 нас баралт буюу 50.0% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 28 тохиолдол байна.

### АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар амбулаторид нийт 296043 үзлэг хийгдсэнээс 29.2 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 59.1 хувийг өвчний учир амбулаторид, 4.8 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 4.7 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 2.2 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.




Амбулаторийн үзлэг,  
2022-2023 оны эхний 7 сарын байдлаар



### ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1169 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92,4 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 96,3 хувь нь хамрагдаж, 1.1 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 7 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.4 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 94.9 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-19 трихомониаз-5, тэмбүү-10 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

Жирэмсэний эрт хяналтын хувь,  
2023 оны эхний 7 сарын байдлаар



### ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2023 оны эхний 7 сарын байдлаар халдварт бус өвчлөл 95495 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 33214 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 6930.0 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1053 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.1 хувийг эзэлж, 10000 хүн амд 76.4 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 1599.1
2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 1372.3
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1269.5
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-753.2
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-567.6


Стационарт нийт 17924 хүн хэвтэж эмчлүүлж, 120533 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 19.1, орны фонд ашиглалт 128.5 фонд ашиглалтын хувь 66.8 байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 7 сарын байдлаар нийт 10948 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 17.5 хувь /1921/ нь алсын дуудлага, 4.2 хувь /456/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 52.1 дуудлага, АНЭ 17.0 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.

### ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 7 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 24141 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 27.5 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.1% эрэгтэй, 58.9% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 4953 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 442 буюу 8.9% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 20920 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 39.5 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 41.4% эрэгтэй, 58.6% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1688 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 26 буюу 1.5% нь онош баталгаажсан байна.





## ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 45759 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 42.6 хувь
- Өвчний учир үзлэг 35.5 хувь
- Диспансерийн хяналт 8.9 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 11.9 хувь
- Гэрийн дуудлага 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 10828 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 5.4 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.2 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 421 жирэмсэн эмэгтэйдгээс 90,7 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 134 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 28 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 47, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 20702 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 15.0 хувь
- Диспансерийн хяналт 2.6 хувь
- Өвчний учир үзлэг 82.4 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 4938 хүн хэвтэн эмчлэгдэж, 35885 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.3 орны эргэлт 16.0 ба орны фонд ашиглалт 116.5, орны фонд ашиглалтын хувь 60.5 байна. Нийт халдварт бус өвчний 26 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 20 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд эхний 7 сарын байдлаар 807 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 58.6 ногдож байна. 2022 оны мөн үед 4635 тохиолдол, 10000 хүн амд 338.7 ногдож байжээ.




10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Алаг-Эрдэнэ, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Цагаан-Үүр,Цэцэрлэг, Мөрөн суманд аймгийн дунджаас өндөр байна. Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 60.2 хувь, сүрьеэ 5.8 хувь, амьсгалын замын өвчин 14,9 хувь, цусан халдвар 0.7 хувь, гэдэсний халдварт өвчин 10.9, арьс салтстаар халдварлах халдвар 0.9, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0,9 хувь, Ковид-19 халдвар 5.7 хувийг тус тус эзэлж байна.

## ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 321 тохиолдлоос:


- Сальмонеллэз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит С 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Ковид-19 46 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3812 тохиолдлоор тус тус буурч
- Сүрьеэ 47 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор
- Цусан суулга 33 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 16 тохиолдлоор
- Хоолны хордлого 52 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 46 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хачигт энцефалит 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 4 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 7 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор
- Салхинцэцэг 101 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 57 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 16 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 15 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 3 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.



## ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


1. 2023 оны эхний 7 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 265 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 23.4 хувь (62), цэврүүт тууралт 40.4 хувь (107), цочмог халууралт, цусархаг тууралтат 11.3 хувь (30), шарлалттай 2.3 хувь (6), цочмог усархаг 2.3 хувь (6), суулгалт хоолны хордлогот халдвар 20.4 хувь (54) тус тус бүртгэгдсэн байна.

2. Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/




Тууралттай хамшинжийн тохиолдол  
мэдээлэгдсэн долоо хоногоор

■ 2022 он  
■ 2023 он



Суулгалттай хамшинжийн тохиолдол  
мэдээлэгдсэн долоо хоногоор


■ 2022 он ■ 2023 он




### ТОМУУ, ТОМУУ ТЭСТ ӨВЧИН

2023 оны эхний 7 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 17209 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1248.9 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 18064 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1320.1 болсон байна.


Томуу, томуу тест өвчин, 10 000 хүн амд




Томуу томуу төст өвчин, долоо хоногоор



Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар)





АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар)



## БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 60.2% (486) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 13.9% (646) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Гонококкт халдвар 374 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 149 тохиолдлоор
- Трихомониаз 25 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 11 тохиолдлоор тус тус буурч
- Тэмбүү 87 тохиолдол буюу өмнөх оны мөн үетэй адил тохиолдол байна.



ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТҮВШИНБАЯР  
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА